



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Зам тээврийн сайдын төсвийн багцын
2014 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/06/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



Зам тээврийн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,

Тэргүүлэх аудитор С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:

enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл

Утас: 260512

Цахим хаяг:

oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Гэрэл

Утас: 261740

Цахим хаяг:

gerelts@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр

Бага тойруу 3

Улаанбаатар-15160

Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

Агуулга

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 18 дугаар зүйлийн 18.2-т тус тус заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам тээврийн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Зам тээврийн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Улсын төсвийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөхөд энэхүү аудитын зорилт оршино.

Зам тээврийн сайдын төсвийн багцын удирдлага санхүүгийн тайлангаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352, 2013 оны 269, 2014 оны 5, 55 дугаар тушаалаар баталсан Улсын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан Улсын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Байгууллагын эрх зүйн орчин

Зам тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд доорх хуулиудыг мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулж байна.

- Авто замын тухай
- Авто тээврийн тухай
- Засгийн газрын тухай
- Яамны эрх зүйн байдлын тухай
- Төрийн хяналт шалгалтын тухай
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай” УИХ-ын 2012 оны 14 дүгээр тогтоол

- “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлах тухай УИХ-ын 2012 оны 120 дугаар тогтоол

Үйл ажиллагааг тодорхойлсон дүрэм, журам

- Зам, тээврийн сайдын 2014 оны 116 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн яам болон харъяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”
- Зам, тээврийн сайдын 2013 оны 154 дүгээр тушаалаар батлагдсан “Зам, тээврийн салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг санхүүжүүлэх журам”,

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Зам, тээврийн яамны эрхэм зорилго бол эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн аюулгүй, ая тухтай үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал юм.

Дээрх эрхэм зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээврийн яам нь дор дурдсан тэргүүлэх чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг хангахуйц зам, тээврийн сүлжээг бий болгох;
- Дэвшилтэт техник, технологи, тээврийн шинэ төрөл, тээвэр ложистикийн тогтолцоог нэвтрүүлж, хэрэглэгчийн эрэлтэд нийцсэн, аюулгүй, шуурхай тээвэрлэлтийн үйлчилгээг бий болгон хөгжүүлэх;
- Хууль тогтоомж, стандарт, норм, нормативыг шинэчилж, салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх;
- Салбарын хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Салбарын боловсон хүчинг бэлтгэх, мэргэшүүлэх, боловсролыг нь дээшлүүлэх оновчтой тогтолцоог нэвтрүүлж, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах зэрэг болно.

Аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүн

Зам тээврийн сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2015 оны 4 дүгээр сарын 20-ноос 25-ны хооронд УАГ-ын САГ-ын дарга С.Энхзаяа удирдаж, аудитын менежер С.Оюунгэрэл чанарын хяналтыг хэрэгжүүлж, Ахлах аудитор Ц.Гэрэл шинэчлэн батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн аудитор хуульд заасан шаардлагын дагуу “Сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл”-ийг холбогдох маягтын дагуу гаргаж, газрын даргын баталгаажуулалт хийлгэн, архивын нэгжид хадгалсан болно.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн урьдчилан боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн болно.

Зам тээврийн сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, түүвэрчлэн шалгах аудитын горимыг хэрэгжүүлж, аудитын явцад нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, тооцооллуудыг нарийвчилсан сорилын аргаар шалгалаа.

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтрийн хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзсэн нь санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргах үндэслэл болсон.

Төлөвлөлтийн шатанд Зам тээврийн сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын түвшинг тайлант оны мөнгөн гүйлгээний тайлангаарх нийт зарлагын 2 хувиар тооцож 11,985.4 сая төгрөгөөр тогтоолоо. Төсвийн санхүүжилттэй салбар тул нийт мөнгөн зардлыг материаллаг байдлын суурь болгон авлаа.

Объект дээрх ажлын үе шатанд төлөвлөлтийн үеийн төсөөллөөс онцын зөрүүтэй асуудал гараагүй тул материаллаг байдлын түвшинг шинэчлэн тогтоогоогүй болно.

Тус яам санхүүгийн үйл ажиллагааг Зам, тээврийн сайдын 2013 оны 154 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж, “Санхүүгийн тооцоолох компанийн нягтлан бодох бүртгэлийн “Acolus”, нэгтгэлийг Пластик програмыг ашиглан холбогдох аргачлал журмын дагуу санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргаж 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 03/1288 дугаар албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн байна.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу олж тогтоосон эрсдэлтэй асуудалд нарийвчилсан сорилыг явуулж, үр дүнг ТАБ-СТА-В-3 маягыг ашиглан холбогдох дансдаар баримтжууллаа.

Мөнгөн хөрөнгийн дансны нийт олонлогоос санамсаргүй түүврийн аргаар сонголт хийсэн түүврийн сорилын үр дүнг ТАБ-СТА-В-5 маягтаар болон excel програмаас филтердэж баримтжууллаа.

Бидний хийж буй 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудитын цаг хугацаатай давхцан “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийгдэж байгаа, УИХ-ын Төсвийн Байнгын хорооны хүсэлтээр “Авто замын салбарт 2014 оны байдлаар гадаадын зээл, буцалтгүй тусламж, Хөгжлийн банкны санхүүжилт, Чингэс, Самурай бондын хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж тайлан 2015 оны 2 дугаар сард гарсан байх тул хамрах хүрээг зохих хэмжээнд хязгаарласан болно.

Олж тогтоосон эрсдэл, үр дагавар

Төлөвлөлтийн шатанд урьдчилсан таамаглалын дагуу дараах эрсдэл байж болох магадлалтай гэж үзсэн бөгөөд хэрэв эрсдэл байгаа тохиолдолд гарах үр дагаврыг тодорхойлсон болно.

Олж тогтоосон гол эрсдэл	Үр дагавар
- Санхүүгийн тайланд зарим үзүүлэлт зөрүүтэй тусгагдсан байх, - Санхүүгийн тайлангийн нэгтгэл алдаатай хийгдэх	- Сайдын төсвийн багцын санхүүгийн үзүүлэлт буруу илэрхийлэгдэх - Сайдын төсвийн багцын санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус яаманд салбарын сайдаар ахлуулсан Дотоод аудитын хороо, яамны бүтцэд Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар ажиллаж байна.

Дотоод аудитын дүрэм, Дотоод аудитын хорооны дүрэм, Дотоод аудитын гарын авлага, Сангийн сайдын 2014 оны 11 дүгээр тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” зэрэг материалаар холбогдох хүмүүсийг хангасан байна.

2014 онд Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв болон Авто тээврийн үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн байна. Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үнэлж, авах арга хэмжээний талаар ТНБД-ын 2014 оны 234 дүгээр тушаалаар баталсан төлөвлөгөөнд холбогдох заалтуудыг оруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Зам тээврийн сайдын төсвийн багцад 314.4 тэрбум төгрөгийн төсөв зарцуулахаар баталсан бол гүйцэтгэлээр 344.6 тэрбум төгрөг зарцуулж, 30.2 тэрбум төгрөгөөр хэтэрсэн дүнтэй байна.Үүнд,

Улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 142.7 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 114.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 28.3 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.

Гадаадын төслийн зээлийн санхүүжилтээр 146.2 тэрбум төгрөгийн барилга байгууламжийн ажлыг санхүүжүүлэхээс 210.8 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлж, 64.6 тэрбум төгрөгөөр хэтэрч харагдаж байгаа нь зарим төслийн 2013 оны барилгын ажлын гүйцэтгэлийг 2014 онд санхүүжүүлсэн, Олон улсын шинэ нисэх буудал

барих төслийн 2014 оны ажлын гүйцэтгэлийн 5 удаагийн төлбөрийн нэхэмжлэлийг Монгол Улсын төсвийн хүндрэлтэй байдлыг харгалзан гадаадын зээлийн хөрөнгөөс олгосонтой холбоотой байна.

Сайдын төсвийн багцын урсгал зардал 23.6 тэрбум төгрөг зарцуулахаас 17.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж 6.0 тэрбум төгрөгийг хэмнэсэн дүнтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын нэгдсэн сайтад бүртгүүлж нэвтрэх код авч холбогдох мэдээллээ байршуулсан байна.

Үүний тулд “Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх тухай” Зам, тээврийн сайдын 2015 оны 03 дугаар тушаалаар цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, хариуцах албан тушаалтныг жагсаалтаар баталсан байна. Мөн тус яамны албан ёсны mrt.gov.mn вэйб сайтад тусгай цэсийг нээж, мэдээллийг давхар оруулдаг байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Засгийн газрын 2014 оны 155 дугаар тогтоолоор МИАТ ХК-ийн Засгийн газрын баталгаатай зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр 4,167.3 мянган ам долларыг 2014 ондоо буцаан төлүүлэх нөхцөлтэйгээр тус компанид олгохоор шийдвэрлэсэн байна.

Тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас 7,341.3 сая төгрөгийн санхүүжилтийг ЗТЯ-ны нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар дамжин МИАТ ХХК-д олгож, яамны аппаратын санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагын гүйлгээ тусгагдсан байна.

Засгийн газрын 155 дугаар тогтоолоор зээлийн эргэн төлөлтийг Зам тээврийн сайдад хариуцуулсантай холбоотойгоор тус яамны дансаар дамжуулсан бөгөөд эргэн төлөлтийн хуваарь ёсоор 2014 оны 11 дүгээр сард төлж дуусах ёстой боловч НӨАТ-ын буцаан олголтын 1,038.0 сая төгрөг суутган тооцож, 2014 оны эцэст 6,503.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аудитаар илрүүлсэн зүйлс болон тэдгээрийг шийдвэрлэсэн тухай

2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах асуудал илэрснийг тус яамны санхүүгийн удирдлагатай хэлэлцэж дараах байдлаар шийдвэрлэсэн болно. Үүнд:

Зам тээврийн сайдын 2014 оны төсвийн багцад авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын зориулалтаар батлагдсан 22.6 тэрбум төгрөгийн төсвийн задаргааг сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталж, 98 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Үүний дотор Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн конторын барилгын дуусгалд 65.7 сая, 5 ширхэг зөөврийн авто пүү авч АЗЗА-ын компаниудад нийлүүлэхэд 202.5 сая, нийт 268.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанартай зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна. Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтын тухай ойлголт болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд тусгах тухай хуульчилсан байна.Тухайлбал,

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ гэж, 29 дүгээр зүйлийн 29.3.3-т "... тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах", 29.3.4-т "санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах" гэж тус тус заасан байна.

Гэтэл Зам тээврийн яамны холбогдох албан тушаалтнууд Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т "Улсын авто замын санг ... замын үйлдвэрлэлийн баазыг хөгжүүлэх,... арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна" гэж заасныг үндэс болгосон тухай тайлбарлаж байна.

Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т "Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ" гэж заасан байна. Эндээс үзвэл Авто замын тухай хууль 1998 онд, Төсвийн тухай хууль 2011 онд батлагдсан байх тул Төсвийн тухай хуулийг мөрдөх ёстой байна.

- Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтад зориулсан төсвөөс хөрөнгө оруулалтын шинж чанартай зүйлс худалдан авахыг зогсоох талаар зөвлөмж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

2014 онд тус яамны барьцаа баталгааны харилцах данснаас 13,520.9 сая төгрөгийн зарлага гарсан байна. Гүйцэтгэгчийн гэрээний үнийн дүнгийн 5.0 хувийг уг харилцахад байршуулж, улсын комиссын акт гарсан тохиолдолд барьцаа хөрөнгийн 50 хувийг, гэрээнд заасан баталгаат хугацаа дууссан тохиолдолд үлдсэн 50 хувийг олгож байна.

Түүвэрт хамрагдсан зарим автозамын барилга угсралтын ажлын гэрээнд баталгаат засварын хугацааг 365 хоногоор тусгаж байгаа нь 2008 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Барилгын чанарын баталгаат хугацаа гурван жил байна" гэж заасан шаардлагыг хангаагүй байна. Энэ нь улсын комиссын акт гарснаас хойш нэг жил өнгөрсөн тохиолдолд гарч болох эвдрэл гэмтлийн засварын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эрсдэл үүсэхээр байна.

- Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Барилгын чанарын баталгаат хугацаа гурван жил байна" гэж заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх нь зүйтэй гэж үзлээ.

Материаллаг бус залруулагдаагүй алдааны талаарх тайлбар

Материаллаг бус залруулаагүй алдаа гараагүй болно.

Анхаарал хандуулах бусад асуудал

Арвайхээр-Баянхонгор-Алтайн чиглэлийн авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлын гүйцэтгэгч Номгон хайрхан ХХК 2012 оноос гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, аймаг орон нутгаас энэ асуудлыг удаа дараа тус яаманд тавьсаар байхад 2013 онд 473.3 сая төгрөгийн гэрээ шинээр байгуулж 134.0 сая төгрөгийн урьдчилгаа олгож, ажлаа хийгээгүйн улмаас авлага үүсгэсэн байна.

Сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчийн 2014 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 107 дугаар захирамжаар Номгон хайрхан ХХК-иас дээрх төлбөрийг албадан гаргуулахаар шийдвэр гарсан боловч өнөө хэр нь барагдуулаагүй байна.

Дараа жилүүдийн аудитаар авч үзэх асуудлууд

2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах үед энэ аудитаар хөндөгдсөн асуудал болон өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг авч үзнэ.

Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг Тээвэр, авто замын газрыг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-т нэгтгэн зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу эдгээрийн нэгтгэл, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн зөв хийгдсэн эсэхийг шалгана.

Мөн Сум дундын 3 дугаар шүүхийн шүүгчийн захирамжийн дагуу Номгон хайрхан ХХК-иас 134.0 сая төгрөгийн авлагыг барагдуулсан эсэхийг шалгана.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Зам тээврийн салбарын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 30 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд 23 зөрчилгүй, 4 тайлан хязгаарлалттай санал дүгнэлт авч, бусад нь түүвэрт хамрагдсан байна. Аудитаар салбар нэгжүүдэд 42,818.5 сая төгрөгийн 18 зөрчилд зөвлөмж өгч, 104.9 сая төгрөгийн төлбөрийг барагдуулах 5 акт тогтоож, 9,895.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

ЗТЯ 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг салбараар нэгтгэн гаргаж, 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1/3995 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Зөвлөмж

Аудитаар Төрийн санд байршиж буй Зам тээврийн яамны Барьцаа баталгааны данс, авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын хөрөнгөнөөс гарч буй зарцуулалтын талаар хоёр зөвлөмж өглөө.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Бид Зам тээврийн сайдын төсвийн багцын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210648 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2015.04.24 № 812

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам тээврийн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газартай: Санал

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам тээврийн сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын тусар А4 бичиг.



ЗАМ ТЭЭВРИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс

Асуудал 1:

Авто замын засвар арчлалтын зардал

Асуудал 2:

Барьцаа баталгааны харилцах данс

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг ЗТЯ-ны санхүүгийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь ЗТЯ-ны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Зам тээврийн яамны санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга З.Цэрэнчимэг, ерөнхий нягтлан бодогч Ч.Ренчиндамба болон бусад санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Сайдын төсвийн багцад авто замын засвар арчлалт зориулалтаар батлагдсан хөрөнгөөс Эрдэнэсант АЗЗА ТӨХК-ийн конторын барилгын дуусгалд 65.7 сая, 5 ширхэг зөөврийн авто пүү авч АЗЗА-ын компаниудад нийлүүлэхэд 202.5 сая, нийт 268.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанартай зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ гэж, 29 зүйлийн 29.3.3-т "... тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах", 29.3.4-т "санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хөрөнгө оруулалтын зардлыг төсөл арга хэмжээ бүрээр хэлэлцэн батлаагүйгээс шаардлагагүй хөрөнгө бэлтгэгдэх, төсвийн хөрөнгө үрэлгэн зарцуулагдах;

ҮАГ-ын зөвлөмжүүд

Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтад зориулсан төсвөөс хөрөнгө оруулалтын шинж чанартай зүйлс худалдан авахыг зогсоох;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшилцсөн.

ҮАГ-ын ажиглалт

2014 онд тус яамны барьцаа баталгааны харилцах данснаас 13,520.9 сая төгрөгийн зарлага гарсан байна. Гүйцэтгэгчийн гэрээний үнийн дүнгийн 5.0 хувийг уг харилцахад байршуулж, улсын комиссын акт гарсан тохиолдолд дээрх барьцаа хөрөнгийн 50 хувийг, гэрээнд заасан баталгаат хугацаа дууссан тохиолдолд үлдсэн 50 хувийг олгож байна.

Түүвэрт хамрагдсан зарим авто замын барилга угсралтын ажлын гэрээнд баталгаат засварын хугацааг 365 хоногоор тусгаж байгаа нь 2008 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Барилгын чанарын баталгаат хугацаа гурван жил байна" гэж заасан шаардлагыг хангаагүй байна.

Эрсдэлүүд

1 дэх жилээс 3 жилийг дуусталх хугацаанд гарч болох эвдрэл гэмтлийн засварын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эрсдэл үүсэхээр байна.

ҮАГ-ын зөвлөмжүүд

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т "Барилгын чанарын баталгаат хугацаа гурван жил байна" гэж заасныг мөрдөж ажиллах, дээрх хугацааг 365 хоногоор заасан өмнөх гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлд тусган танилцуулж, зөвшилцсөн.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
НИЙТ ДҮН	-	-
МӨНГӨН ХӨРӨНГӨ	37,482,405,196.70	47,953,792,016.58
Кассанд байгаа бэлэн мөнгө	44,151,174.09	43,104,642.21
Төгрөг\ ЖМС	43,383,671.69	27,831,282.21
Гадаад валют	767,502.40	15,273,360.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	37,438,254,022.61	47,910,687,374.37
Төгрөг	37,438,254,022.61	47,910,687,374.37
Төсөвт байгууллагын харилцах	21,070,343,108.97	19,706,500,721.64
Төсөвт байгууллын харилцах (Арилжааны банк)	12,809,132,199.84	28,204,186,652.73
Нэмэлт санхүүжилтийн харилцах	3,558,778,713.80	-
АВЛАГА	44,850,319,170.18	58,216,975,187.68
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,991,220.24	3,629,886.45
Төлбөртэй үйлчилгээний авлага	27,047,170,011.52	36,944,512,851.23
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	-	7,561,875,519.10
Бусад авлага	17,800,157,938.42	13,706,956,930.90
Байгууллагаас авах авлага	17,741,165,175.17	13,586,072,376.11
Шуудан холбооны авлага	-	58,465.00
Бусад зардлын тооцооны авлага	17,741,165,175.17	13,586,013,911.11
Хувь хүмүүсээс авах авлага	58,992,763.25	120,884,554.79
УРЬДЧИЛГАА	63,139,413,491.26	198,130,970,793.06
Бусад урьдчилгаа	63,139,413,491.26	198,130,970,793.06
Урьдчилгаа тооцоо	5,500,000.00	-
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	5,500,000.00	-
Урьдчилж гарсан зардал	63,133,913,491.26	198,130,970,793.06
Урьдчилж төлсөн зардал	63,133,913,491.26	198,130,970,793.06
БАРАА МАТЕРИАЛ	7,123,222,513.22	6,411,608,926.99
Түүхий эд материал	6,027,272.00	5,375,247.50
Тусгай зориулалттай материал	5,410,845.00	4,859,630.00
Бэлэн бүтээгдэхүүн	616,427.00	515,617.50
Хангамжийн материал	7,079,480,031.37	6,356,961,277.16
Бичиг хэргийн материал	97,243,699.23	60,256,501.11
Аж ахуйн материал	6,852,418,811.73	6,173,884,396.90
Сэлбэг хэрэгсэл	13,281,594.60	10,328,242.60
Түлш, шатах тослох материал	8,342,097.29	11,023,272.27
Барилгын засварын материал	2,797,070.00	3,178,485.00
Хүнсний материал	661,600.00	985,860.00
Бусад бараа материал	104,735,158.52	97,304,519.28
Мал амьтад	8,731,938.66	9,861,938.66
Бусад	28,983,271.19	39,410,463.67
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,595,360,371.36	310,713,346,924.31
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,060,015,284,273.25	2,436,780,067,605.99
Биет хөрөнгө	2,057,635,131,387.96	2,432,340,092,980.21
Барилга, байгууламж, орон сууц	103,948,003,381.97	102,641,572,737.00

Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	157,413,597,022.39	161,274,491,318.05
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(53,465,593,640.42)	(58,632,918,581.05)
Авто-тээврийн хэрэгсэл	6,820,691,554.82	7,307,250,743.46
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	21,922,265,830.36	22,710,484,274.96
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(15,101,574,275.54)	(15,403,233,531.50)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	46,843,749,950.42	61,984,628,096.44
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	99,773,425,515.79	121,722,987,559.71
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(52,929,675,565.37)	(59,738,359,463.27)
Тавилга, аж ахуйн эд хогшил	2,550,400,857.16	2,141,797,601.45
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	6,140,312,409.10	6,018,535,253.93
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(3,589,911,551.94)	(3,876,737,652.48)
Зам, гүүрийн байгууламж	428,481,673,877.46	1,104,140,017,730.14
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	1,070,380,461,249.84	1,775,285,476,438.68
Зам, гүүрийн байгууламж - Хуримтлагдсан элэгдэл	(641,898,787,372.38)	(671,145,458,708.54)
Бусад үндсэн хөрөнгө	24,305,773.87	19,089,582.00
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	38,223,142.00	38,223,142.00
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(17,924,368.13)	(22,288,560.00)
Номын фонд	4,007,000.00	3,155,000.00
Дуусаагүй барилга, байгууламж	1,468,966,305,992.26	1,154,105,736,489.72
Биет бус хөрөнгө	2,380,152,885.29	4,439,974,625.78
Програм хангамж	2,379,927,263.68	4,439,954,834.21
Програм хангамж - Анхны өртөг	5,164,398,359.29	8,150,978,284.94
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(2,784,471,095.61)	(3,711,023,450.73)
Бусад биет бус хөрөнгө	225,621.61	19,791.57
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	450,000.00	450,000.00
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(224,378.39)	(430,208.43)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,212,610,644,644.61	2,747,493,414,530.30
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,537,055,009.08	50,320,149,561.00
Өглөг	24,522,093,982.45	50,299,669,320.65
Ажилчидтай холбогдсон тооцоо	81,581,803.67	9,348,849.57
Цалингийн өглөг	10.00	264,400.00
НДШ-ийн өглөг	15,962,409.77	6,530,815.86
ХАОАТ-ын өглөг	65,592,040.90	2,553,633.71
ҮЭ-ийн өглөг	27,343.00	-
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	15,114,061.60	4,854,297.00
Гэрэл цахилгааны тооцоо	-	20,619.00
Түлш халаалтын тооцоо	2,412,984.00	826,484.00
Шуудан холбооны тооцоо	241,729.60	168,745.00
Цэвэр, бохир усны тооцоо	-	64,000.00
Тээвэр шатахууны тооцоо	2,390,258.00	17,000.00
Байрны түрээсийн тооцоо	2,000,000.00	2,064,674.00
Байрны засварын тооцоо	431,120.00	-
Бусад зардлын тооцоо	7,637,970.00	1,692,775.00
Бусад өглөг	24,425,398,117.18	50,285,466,174.08
Байгууллагад төлөх өглөг	24,418,792,060.10	50,285,181,834.57

Хувь хүмүүст төлөх өглөг	6,606,057.08	284,339.51
Урьдчилж орсон орлого	14,961,026.63	20,480,240.35
Төсөвт байгууллага	14,961,026.63	20,480,240.35
Урьдчилж орсон орлого	14,961,026.63	20,480,240.35
УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	7,193,094,698.38	2,729,467,229.94
Урт хугацаат зээл	7,193,094,698.38	2,729,467,229.94
Гадаад валют	7,193,094,698.38	2,729,467,229.94
Олон улсын санхүүгийн байгууллагаас	7,193,094,698.38	2,729,467,229.94
Төслийн зээл	7,193,094,698.38	2,729,467,229.94
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	31,730,149,707.46	53,049,616,790.94
Засгийн газрын хувь оролцоо	2,180,880,494,937.15	2,694,443,797,739.36
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	574,847,614,462.39	600,321,846,002.46
Хуримтлагдсан үр дүн	1,479,386,601,687.14	1,967,475,672,949.28
Өмнөх үеийн үр дүн	1,479,386,601,687.14	1,345,031,564,187.81
Тайлант үеийн үр дүн	-	622,444,108,761.47
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	126,646,278,787.62	126,646,278,787.62
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,180,880,494,937.15	2,694,443,797,739.36
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	2,212,610,644,644.61	2,747,493,414,530.30

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
НИЙТ ДҮН	-	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	638,542,608,359.51	375,545,794,337.77
Олон улсын байгууллагын тусламж	41,329,341,957.14	18,935,041,753.53
Урсгал тусламж	297,299,371.37	496,964,923.61
Хөрөнгийн тусламж	41,032,042,585.77	18,438,076,829.92
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	597,213,266,402.37	357,648,815,254.26
Улсын төвлөрсөн төсвөөс	320,121,292,761.81	140,428,774,704.54
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,476,342,220.00	11,567,378,700.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	219,000,000.00	-
Хөрөнгийн	289,527,519,442.21	116,117,596,255.06
Нэмэлт санхүүжилтийн орлого	12,898,431,099.60	11,705,737,079.46
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	51,046,970.00	6,802,076,958.43
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	15,700,565.83	44,635,086.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,318,030,594.77	4,854,472,521.03
Төсвийн урамшуулал	1,513,652,969.00	4,552,514.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	449,217,143.00	1,000,000,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	96,566,700.00	-
Хөрөнгийн	352,650,443.00	1,000,000,000.00
Төсөвт байгууллагаас	45,307,054,420.46	-
Өр барагдуулах санхүүжилтийн орлого	39,050,572,267.64	-
ТЕЗ-аас олгосон санхүүжилт	6,256,482,152.82	-
Нийгмийн даатгалын сангаас	35,074,868.00	22,661,103.00
НДС-ийн шилжүүлэг	35,074,868.00	22,661,103.00
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	231,300,627,209.10	216,197,379,446.72
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2,781,200.00	-
Гадаад төслийн зээлээс санхүүжих	231,297,846,009.10	216,197,379,446.72
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	857,513,525,271.82	526,270,561,713.75
Өмчийн орлого	11,806,091.50	14,723,242.33
Хүүгийн орлого	11,806,091.50	14,723,242.33
Бараа, үйлчилгээний борлуулалт	857,484,419,180.32	526,255,838,471.42
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	715,657,169,558.09	357,357,835,037.57
Үндсэн үйл ажиллагааны орлого	19,724,351,495.43	7,289,185,872.04
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	655,325,252,376.80	12,973,598,388.80
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,607,565,685.86	337,095,050,776.73
Навигацийн орлого	141,827,249,622.23	168,898,003,433.85
Татварын бус бусад орлого	17,300,000.00	-
Хөрөнгийн орлого	17,300,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,496,056,133,631.33	901,816,356,051.52
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	48,446,862,122.64	44,659,416,761.70

Үндсэн болон нэмэгдэл цалин	43,726,636,070.61	42,162,398,502.14
Үндсэн цалин	39,211,993,797.49	31,799,629,819.42
Гэрээт ажилчдын цалин	1,830,040,884.56	7,859,256,587.52
